



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ



## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

(Аж ахуйн нэгж байгууллага)

ГЭРЭЭНИЙ ДУГААР: .

ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР:

*Барилга хот байгуулалт*

ХЭРЭГЛЭГЧИЙН КОД:

*5506842*

## ХЭРЭГЛЭГЧДИЙН АНХААРАЛД

### Гэрээ байгуулах, сунгах үндсэн нөхцөл

Оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ Засаг захиргааны үндсэн нэгжид бүртгэлтэй барилга, объектыг өмчлөх, дэвсгэр газрыг ашиглаж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зорилгоор эзэмших зөвшөөрөлтэй байх.

Дээрх нөхцөлийг хангах боломжгүй тохиолдолд гэрээний 1.1 дэх заалтыг хангасан, өөрийнх нь үйл ажиллагаа явуулах барилга объектын өмчлөгч этгээдтэй "Батлан даалт" гэрээг байгуулан түр эзэмшигч буюу түрээслэгч нь тусдаа "Цахилгаан эрчим хүчээр хангах" гэрээ байгуулж болно.

Барилга байгууламж нь шугам сүлжээний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвасын гадна байх.

### Хангагч-хэрэглэгчийн хооронд харилцах утас:

#### Хангагчийн:

Цахилгааны дуудлага өгөх

Утас № 70592500.....

#### Хэрэглэгчийн:

Ажлын утас № 70592535.....

Гар утас № 80066876.....

Та хангагчийн эрх бүхий ажилтны үнэмлэхийг шалгаж үйлчлүүлнэ үү.

## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ № .....

(Үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага болон үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг иргэнтэй байгуулах гэрээ)

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нэг талаас "Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ" Төрийн Өмчит Хувьцаат Компани /"БЗӨБЦТС" ТӨХК/-ийг төлөөлж <sup>24</sup>.....  
Цахилгаан Түгээх Сүлжээ Салбар /ЦТССалбар цаашид "Хангагч" гэх/ албан тушаалтай..... овогтой <sup>Төрлөгчид</sup>..... нөгөө талаас <sup>Хангагч</sup>.....-ийг төлөөлж <sup>Хангагч</sup>..... албан тушаалтай ..... овогтой <sup>Хангагч</sup>..... цаашид "Хэрэглэгч" гэх/ нар харилцан тохиролцож Монгол Улсын "Иргэний хууль", "Эрчим хүчний тухай хууль", "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", "Цахилгаанаар Зохицуулалттай Хангах Тусгай Зөвшөөрөл Эзэмшигч – Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм", Монгол Улсын стандарт "Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага" болон бусад хууль тогтоомжуудыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдон гарах, гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг "Эрчим хүчний тухай хууль", "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм", "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм", "Цахилгаанаар Зохицуулалттай Хангах Тусгай Зөвшөөрөл Эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм", "Нэгдсэн сүлжээний дүрэм"-ийн заалтуудыг баримтлан зохицуулна.
- 1.1. Энэхүү гэрээнд орсон хавсралтууд нь салшгүй хэсэг болно. Үүнд:
- 1.1.1. *Хавсралт №1* Хангагч хэрэглэгчийн цахилгаан шугам, дэд станц, тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээний заагийн схем;
- 1.1.2. *Хавсралт №2* Хэрэглэгчийн харьяа объектуудын тооцооны хэмжих хэрэгслийн үзүүлэлт
- 1.1.3. *Хавсралт №3* Хэрэглэгчийн суурилагдсан хүчин чадал болон тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал;
- 1.1.4. *Хавсралт №4* ЦЭХ-ний захиалга ба захиалгад орох нэмэлт, өөрчлөлт
- 1.1.5. *Хавсралт №5* Тоног төхөөрөмж болон тооцооны хэмжих хэрэгсэлд туршилт хийгдсэн акт, тоолуур баталгаажуулсан гэрчилгээний хуулбар;
- 1.1.6. *Хавсралт №6* Тус байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээ, захирлын иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 1.1.7. *Хавсралт №7* ЦЭХ-ээр хангах гэрээний биелэлтийг дүгнэх акт
- 1.2. Энэхүү гэрээ нь 20..... оны .....сарын .....-ны өдрөөс 20..... оны .... сарын ....-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд холбогдох хууль тогтоомжинд өөрчлөлт орсон тохиолдолд талууд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулж болно.
- 1.3. Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг байгуулсан хугацаагаар дахин 1 удаа сунгасанд тооцно.

### Хоёр. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 2.1. Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай хууль"-д зааснаас гадна дараах эрхтэй.
- 2.1.1. Монгол улсад мөрдөгдөж буй стандартын шаардлага хангасан, цахилгаан хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага хэрэглэгчийн зэрэглэлд нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангагдах.
- 2.1.2. Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлөх
- 2.1.3. Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай хууль" болон энэхүү гэрээнд зааснаас бусад үндэслэлээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо нэхэмжлэх
- 2.1.4. Хэрэглэгч нь эрчим хүчний хэрэглээтэй холбоотой, санал гомдол, гэмтэл саатлыг <sup>Хэрэглэгчдэд</sup> Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дуудлага хүлээн авах утсанд мэдэгдэж засуулах

- 2.1.5. Хангагчийн болон хангагч байгууллагын ажилтнуудын үзүүлж байгаа үйлчилгээ, үйл ажиллагаа, харилцааны талаарх санал, хүсэлт гомдлыг БЗӨБЦТС ТӨХК-ийн 7021-3895 дугаарын утсанд, компанийн харьяа ЦТС салбаруудын Хэрэглэгчдэд үйлчлэх төв /ХҮТ/-ийн хангах хэсэгт, мөн салбарын удирдах дээд шатны байгууллага, хууль хяналтын байгууллагад мэдээллэх, гомдол гаргах
- 2.1.6. Цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх хүсэлтээ хангагчид тавих эрхтэй бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэглэгч хариуцах
- 2.1.7. Өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ, шинэчлэлттэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах
- 2.1.8. Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолтой, хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан, мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол нэмэлтээр шуурхай ажиллагааны гэрээг байгуулан мэргэжлийн байгууллагаар үйлчлүүлэх
- 2.1.9. Хэрэглэгч компанийн эзэмшлийн биш дэд станц, шугам тоноглолоос цахилгаан эрчим хүчээр тэжээгддэг бол засвар үйлчилгээний ажилд зөвлөгөө авах, төлбөрт үйлчилгээ хийлгэх
- 2.1.10. Цахилгаан эрчим хүчээр хязгаарлуулсан зөрчлийг арилгасан бол цахилгаан эрчим хүчийг сэргээлгэх хүсэлтийг харьяа Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж гаргах
  - 2.1.11. Хангагч талын ажилтны бичиг баримтыг үзэх, шалгах
    - 2.2. Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай хууль"-д зааснаас гадна дараах үүрэгтэй.
      - 2.2.1. Хэрэглэгч өөрийн тухай мэдээлэл болон цахилгаан шугам, тоноглолынхоо схем, горим, зориулалт, хүчин чадал, үзүүлэлтүүдийг хангагчид үнэн зөв өгөх, мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдол бүрт нэн даруй хангагчид мэдэгдэж байх. Энэ тухай хангагчид мэдэгдээгүй бол үүсэх хохирлыг хангагч тал хариуцахгүй.
      - 2.2.2. Байр, орон сууц, хашаа, газрыг шинээр худалдан авсан, өвлөн авсан, бэлгэлэлийн гэрээгээр авсан хэрэглэгч уг объектын өмнө нь эзэмшиж байсан хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг өөрийн нэр дээр шилжүүлэн авах хүсэлтийг тухай бүрд нь хангагчид гаргах
      - 2.2.3. Эрчим хүчээр хангагчийн төлөөлөгчийг үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангах. Хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд орох, үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх, дэд станцын хаалга, хашааны цоожны түлхүүрийг хоногийн 24 цагаар байнгын бэлэн байдалд байлгах
      - 2.2.4. Эзэмшлийн заагаар цахилгааны шугам сүлжээ, дотор холболт, цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид аюул осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэх
      - 2.2.5. Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд ААД, ТАД-ын дагуу ашиглалт, үйлчилгээ, засварын ажлыг хийх бөгөөд эдгээр шугам тоноглолын ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтныг томилон ажиллуулах эсвэл мэргэжлийн ажилтан, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх
      - 2.2.6. Хэрэглэгч нь нарийн мэдрэмжтэй тоног төхөөрөмж хэрэглэж байгаа бол гүйдэл, хүчдлийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмж тавьсан байх
      - 2.2.7. Хэрэглэгчийн эзэмшлийн цахилгаан дамжуулах шугам, техник тоног төхөөрөмж нь өөрийн хүчин чадалдаа тохирсон байх ба гүйдэл, хүчдлийн хэлбэлзэл, өөрийн хэрэглээний ашиглалтаас гарах, тасралтаас хамгаалах нарийн мэдрэмжтэй автомат төхөөрөмж суурилуулан хамгаалах. Энэ заалтыг хангаагүйгээс гарах хохирлыг хангагч хариуцахгүй.
      - 2.2.8. Хэрэглэгч нь өөрийн нөөц бие даасан цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй байх
      - 2.2.9. Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах
      - 2.2.10. Хэрэглэгч нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцах
      - 2.2.11. Хэрэглэгч нь өөрийн эзэмшиж буй цахилгааны шугам сүлжээ, дотор холболт, цахилгаан хэрэгслийн ашиглалт аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан

- сэргийлэх ажлыг бүрэн хариуцах ба энэ ажлыг хариуцсан ажилтныг тусгайлан томилж ажиллуулах
- 2.2.12. Хэрэглэгч нь хэрэглэсэн цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх, төлөөгүйгээс гарах хохирлыг өөрөө хүлээж, таслах залгах үеийн үйлчилгээний төлбөр, нөхөн тооцооны төлбөр, алданги, бусад үйлчилгээний төлбөр, сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл хүргэсний хураамжуудыг зохих журмын дагуу хангагчид төлж үйлчлүүлнэ. Хэрэглэгч төлбөрөө хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд 3 өдрийн дотор Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биечлэн ирж асуудлаа шийдвэрлүүлэх.
- 2.2.13. Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг хэрэгжүүлэх, өөрийн эзэмшлийн газарт байгаа цахилгаан тоног төхөөрөмжийг хамгаалах, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, кабелийн болон агаарын шугамын хамгаалалтын зурваст газар шорооны болон бусад ажлыг хангагчийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй, бусдаар гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй ба хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн шугам тоноглолоос бусад хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахыг хориглоно.
- 2.2.14. Хангагчийн цахилгаан түгээх сүлжээний хэвийн ажиллагаа алдагдах, хүчдлийн огцом хэлбэлзлийн улмаас доорхи тохиолдолд гарсан хохирлыг хангагчийн эрх бүхий ажилтанд нэн даруй мэдэгдэх:
- 2.2.14.1. Хэрэглэгчийн цахилгаан хэрэгсэл шатсан.
- 2.2.14.2. Цахилгаан гүйдэлд хүн, мал, амьтан нэрвэгдэх, гал түймэр гарах аюул бий болсон.
- 2.2.14.3. Хэрэглэгч, хангагчийн тооцоо хийдэг хэмжээ хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан.
- 2.2.15. Тухайн барилга объектыг өмчлөгч нь өөрөө эзэмшиж, ашиглаж байгаа үедээ бусадтай хамтран түр эзэмшсэн, мөн бусдад түрээслүүлсэн тохиолдолд хангагчийн өмнө цахилгаан эрчим хүчний тооцоог зөвхөн өмчлөгч хариуцна.
- 2.2.16. Хэрэглэгч нь дараа жилийн худалдан авах цахилгаан эрчим хүчний хэмжээг урьдчилан 7 дугаар сарын 20-ны дотор гаргаж өгөх үүрэгтэй ба тухайн оныхоо 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө дахин тодотгон өөрчлөлт оруулж болно. Захиалгад хэрэглэгчийн суурилагдсан хүчин чадал, энергийн хэмжээ, хангагч, хэрэглэгчийн гарын үсэг, хаяг, хуулийн этгээдийн тамга тэмдэг байна.
- 2.2.17. Хэрэглэгч нь өөрийн харилцах банкны данс, утас, хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор хангагчид албан ёсоор мэдэгдэх
- 2.2.18. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжид хангагчаар засвар үйлчилгээ хийлгэх тохиолдолд хангагчид 3 хоногийн өмнө захиалга өгөх ба уг ажилтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.
- 2.2.19. Хэрэглэгч нь хангагчаас худалдан авах цахилгаан эрчим хүчний хэмжээг жилийн дүнгийн  $\pm 2$ -оос дээшгүй хувийн өөрчлөлтэй төлөвлөж захиалах. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгадаа "графикийн хазайлт" гаргасан тохиолдолд Эрчим Хүчний Зохицуулах Хороо /ЭХЗХ/-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу хангагчийн тавьсан актыг үндэслэн хэтэрсэн хувь тутамд ногдох хазайлтын төлбөрийг төлөх
- 2.2.20. Эрчим хүчний системийн хэрэглээний төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү буюу графикийн "хазайлт"-д нөлөөлөхүйц хэрэглээний сар бүрийн захиалгыг тусад нь авч дүгнэхийн дээр хэрэглэгч хэрэглээний нэгтгэсэн захиалгаа өмнөх сарын 25-ны дотор, өөрчлөлтийг тусгасан тодотголыг долоо хоног тутмын Даваа гаригт хангагчид хүргүүлнэ.
- 2.2.21. Хэрэглэгч нь 6-35 кВ-ын өндөр хүчдэлийн шугам, тоноглол эзэмшдэг бол харьяа ЦТССалбартай "Цахилгаан тоноглолын найдвартай болон шуурхай ажиллагааны гэрээ"-г байгуулах
- 2.2.22. Цахилгаан шугам, тоноглолын техник ашиглалт, аюулгүй ажиллагааг хангуулах талаар хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх
- 2.2.23. Өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийг цахилгаан эрчим хүчинд холбохгүй байх, суурилагдсан хүчин чадал, хийц, зориулалтыг нь дур мэдэн өөрчлөх, өргөтгөхгүй байх
- 2.2.24. Шугам тоноглолдоо автомат сэлгэн залгагч төхөөрөмж, мөн аваарийн нөөц

тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/ суурилуулах бол аюулгүй ажиллагааны үүднээс хангагчид заавал мэдэгдэж бүртгүүлэх

### Гурав. Хангагчийн эрх, үүрэг

- 3.1. Хангагч нь “Эрчим хүчний тухай хууль”-д зааснаас гадна дараах эрхтэй.
- 3.1.1. Цахилгаан эрчим хүчний шугам, сүлжээний хамгаалалтын зурвас дотор хангагчийн зөвшөөрөлгүйгээр хашаа, байшин, барилга, гэр болон бусад объектыг байршуулсан хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй хэрэглэгчид Эрчим хүчний хууль, тогтоомжийг үндэслэн нөхөн бичилт хийх, алданги торгууль тавих, зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар цахилгаан эрчим хүчний хэрэглээг түтгэлзүүлэх, гэрээг цуцлах эрхтэй.
- 3.1.2. Авлагатай хэрэглэгчийн цахилгаан эрчим хүч сэргээх захиалгыг төлбөрийг бүрэн төлж барагдуулах хүртэл хүлээн авахгүй байх
- 3.1.3. Хангагчийн эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн цахилгаан шугам, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, тооцоо хийхээр хэрэглэгчийн орон байр, барилга байгууламжинд саадгүй нэвтрэн орох
- 3.1.4. Мөнгөн тооцооны хэмжих хэрэгсэл, тэдгээрийн холболтын хэлхээг байрлуулсан хайрцаг, тоолуурын таглаанд хангагчийн эрх бүхий ажилтан ломбо хийж битүүмжлэх
- 3.1.5. Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, нөхөн тооцооны төлбөрийг нэхэмжлэх
- 3.1.6. Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөр, нэмэлт төлбөр, үйлчилгээний хураамж, нөхөн тооцооны төлбөрөө төлөөгүй, хангагчийн шаардлага, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний заалтыг биелүүлээгүй бол төлбөр төлөхийг албан ёсоор шаардах, сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл хүргэх. Хэрэглэгчийн эзэмшлийн шугам тоноглолын ашиглалт засвар үйлчилгээ болон энэхүү гэрээнд тусгагдсан бусад асуудалтай холбогдуулан хэрэглэгчид шаардлага тавих
- 3.1.7. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан “Эрчим хүчний тухай хууль”-ийн 32.2 дугаар заалтыг үндэслэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх
- 3.1.8. Энэхүү гэрээний 3.1.6-д зааснаас гадна хэрэглэгчийн явуулж байгаа үйл ажиллагаа нь Монгол улсын хуулийг зөрчсөн, хүний амь нас, эд хөрөнгөнд нь хохирол учруулсан, хохирол учруулж болзошгүй болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь Улсын байцаагчийн дүгнэлтээр нотлогдсон бол дээрх дүгнэлтийг үндэслэн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх
- 3.1.9. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж тасралт саатал, гэмтэл гарсан тохиолдолд дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний үнэ болон бусад хохирлоо нэхэмжлэх
- 3.1.10. Хангагчийн горим ажиллагаа, цахилгаан эрчим хүчний чанарт сөрөг нөлөө үзүүлэх тоног төхөөрөмж ашиглахыг хориглох
- 3.1.11. Хангагч нь зайлшгүй шалтгааны улмаас хэрэглэгчийн бичилт хийлгэх, төлбөр тооцоо хийх циклийн хугацааг өөрчлөх
- 3.1.12. Хувийн эзэмшлийн трансформатортай хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тооцоон дээр сар бүр трансформаторын хоосон явалтын энерги тооцож авах талаар мэдэгдэж гэрээнд тусгах
- 3.1.13. Хангагч нь хэрэглэгчийн үүсгэсэн өрийн хэмжээ, шүүхийн шийдвэрийг хэрэглэгчид танилцуулан гэрээ цуцлагдсан болохыг мэдэгдэж “БЗӨБЦТС” ТӨХК-ийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгсэл, кабелийг хураан авч акт үйлдэх
- 3.1.14. Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж өр төлбөрөө барагдуулах арга хэмжээ авахгүй байх, авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний нөхцөл зөрчиж төлбөрөө төлөхгүй байгаа хэрэглэгчийг шүүхэд шилжүүлэн төлбөрийг нэхэмжлэх
- 3.1.15. Цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн хэрэглэгчийн тасархай байдлыг 7 хоног тутамд хянах
- 3.1.16. Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох

- 3.2. Хангагч нь "Эрчим хүчний тухай хууль"-д зааснаас гадна дараах үүрэгтэй.
- 3.2.1. Хангагч нь техникийн нөхцөл авсан, цахилгааны төлбөрийн үлдэгдэлгүй, зохих хураамж, төлбөрийг урьдчилан төлсөн хэрэглэгчтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулж, өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээнд холбох
- 3.2.2. Хэрэглэгчийг Монгол улсын стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах
- 3.2.3. Цахилгаан эрчим хүчийг нь хангагчийн зүгээс түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэн зөрчил устгах арга хэмжээг хэрэглэгч авсны дараа, үйлчилгээний төлбөр хураамжууд урьдчилан төлөгдсөн бол хангагч тал хэрэглэгчийн цахилгаан хангамжийг холбогдох журам, стандартад заасан хугацаанд сэргээх
- 3.2.4. Хангагч нь хэрэглэгчийн захиалгаар ажил гүйцэтгэх үед бусад хэрэглэгчийн цахилгаан хангамжийг түр хугацаагаар түтгэлзүүлэх шаардлага гарсан тохиолдолд 24-өөс доошгүй цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх
- 3.2.5. Хангагч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоноглолд төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх таслалтын талаар 24-өөс доошгүй цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх
- 3.2.6. Хангагч нь хэрэглэгчид үүссэн хохирлыг дараах тохиолдолд хариуцахгүй. Үүнд:
- 3.2.6.1. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас болж хангагчийн шугам тоноглол тасарсан.
- 3.2.6.2. Хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмж, хэрэгсэлд гэмтэл гарсан.
- 3.2.6.3. Төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн.
- 3.2.6.4. Хэрэглэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс урьдчилан мэдэгдсэний дагуу эрчим хүчийг түтгэлзүүлсэн.
- 3.2.8. Цахилгаанаар хангахтай холбоотой асуудлаар хэрэглэгчээс бичгээр хүсэлт тавьсан тохиолдолд 15 хоногийн дотор хариу өгнө. Шаардлагатай гэж үзвэл уг хугацааг 15 хоногоор 1 удаа сунгаж болно.
- 3.2.9. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор хангагчийн зөвшөөрөлгүйгээр үл хөдлөх хөрөнгө /хашаа, байшин барилга байгууламж/ барьсан хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй бөгөөд гэрээ байгуулахаас татгалзана.
- 3.2.10. Сард нэг удаа хэрэглэгчийн хэрэглэсэн цахилгааны бичилт хийж тоолуур, хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгана.

### Дөрөв. Цахилгааны үнэ /тариф/ тооцоо, төлбөр хийх журам

- 4.1. Талууд нь цахилгаан эрчим хүчний тооцоо, төлбөрийг хийхдээ ЭХЗХ-ноос батлагдсан үнэ тарифыг мөрдөнө.
- 4.1.1. Ердийн тоолууртай бол  
1 кВт\*цагийн үнэ **187,00** төгрөг
- 4.1.2. Цагийн ялгаварт тоолууртай бол  
1 кВт\*цагийн үнэ  
Өдрийн хэрэглээний тариф /06.00-17.00/ .... **187,00** төгрөг  
Оргил ачааллын тариф /17.00-22.00/ .... **291,00** төгрөг  
Шөнийн хэрэглээний тариф / 22.00-06.00/ **121,00** төгрөг
- 4.1.3. Цахилгааны чадлын тариф:  
1 кВт үнэ ..... төгрөг **11520,00**
- 4.1.4. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф:  
1 кВт\*цагийн үнэ **23** төгрөг **79** мөнгө
- 4.2. ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан цахилгааны үнэ тариф өөрчлөгдөхөөс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр шинэчлэгдсэн үнэ тарифыг зарласан байх бөгөөд 15 хоногийн дотор талууд гэрээнд өөрчлөлт оруулна. Гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь энэхүү үнэ тарифыг мөрдөхөөс татгалзах үндэсэл болохгүй. Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтын тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан, хангагчийн ажилтны битүүмжилсэн тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын заалтыг баримтлан хийнэ.
- 4.3. Хэрэглэгч нь хангагчаар засвар, үйлчилгээ хийлгэхдээ БЗӨБЦТС ТӨХК-иас баталсан журмын дагуу төлбөрт үйлчилгээний үнэ /тариф/-ыг мөрдөж ажиллана.

- 4.4. Хэрэглэгч нь хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг бүрэн төлөх тухай банкны баталгаа гаргуулах, Монгол улсын "Иргэний хууль"-ийн 243.1-р заалт, "Эрчим хүчний тухай" хуулийн 28.3 зааснаар хэрэглэгчийн харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа 1 сарын цахилгаан эрчим хүчний хэрэглээтэй тэнцэх хэмжээний төлбөрийг хангагчийн ХААН банкны 5750371860 тоот дансанд байршуулна.

#### **Төлбөр тооцоо хийх**

- 4.5. Хангагч нь эрх бүхий байгууллагаар баталгаажуулж битүүмжлэгдсэн тоолуурын заалтыг үндэслэн сар бүрийн ...-ны өдрийн дотор хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний тооцооны бичилтийг хийнэ.
- 4.6. Хэрэглэгчээс шалтгаалаагүй тооцооны хэмжих хэрэгсэл шаардлага хангаагүй эсвэл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлахаар сүлжээнээс салгасан бол "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 39 дүгээр заалтыг үндэслэн урьд 3 сарын цахилгаан эрчим хүчний хэрэглээний дунджийг баримтлан тооцоог хийнэ.
- 4.7. Хэрэглэгчийн тоолуурын заалт авах үед тухайн тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байгааг хангагчийн ажилтан илрүүлсэн бол тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэлд хэрэглэгчийн буруутай үйлдэл нөлөөлсөн эсэхийг тогтоож акт үйлдэнэ.
- 4.8. Тооцооны хэмжих хэрэгслийг хангагч хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон явалтын) дахь алдагдлыг шугам сүлжээг эзэмшигч хүлээнэ.
- 4.9. Хэрэглэгчийн хуурмаг хэрэглээнээс хамааруулж ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу чадлын итгэлцүүр (COSФ)-ээс хамаарсан нэмэлт төлбөр тооцно.
- 4.10. Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүчний төлбөр тусгагдахаас гадна шугам болон трансформатор дахь алдагдал, чадлын итгэлцүүр (COSФ)-ээс хамааруулж тооцсон төлбөр, нөхөн тооцооны төлбөр, хугацаа хэтрүүлсний алданги, дараа төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөр хураамж, НӨАТ, бусад нэмэлт төлбөрүүд тусгагдсан байна.
- 4.11. Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө банкинд болон банкны биллинг үйлчилгээ, картаар, дансаар, интернэтээр болон ХҮТ-ийн төлбөр төлөх цэгүүдээр бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлнө.
- 4.12. Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлж болно.
- 4.13. Хэрэглэгч нь хангагчийн төлбөрийн нэхэмжлэл банкинд хүргэгдсэнээс хойш гэрээнд заасан хугацаанд нэхэмжилсэн төлбөрийг төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам "БЗӨБЦТС" ТӨХК-ийн "Алданги тооцох журам"-ын дагуу алданги төлнө.
- 4.14. Байр, орон сууц, хашаа, газрыг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, нүүн шилжих, түрээслэхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусган, энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн байр, орон сууц, хашаа, газрыгшинээр өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч, бэлэглэлээр авагч, өвлөн авагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шаардаж, гаргуулан авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч эрчим хүчний өрийг хариуцна.
- 4.15. Хангагчтай гэрээ байгуулсан үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нас барсан, гадаад, дотоодод 3 сар ба түүнээс дээш удаан хугацаагаар нүүн шилжихдээ хангагчид мэдэгдээгүй, үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч нь цахилгаан хэрэглэсэн төлбөрөө барагдуулалгүй нүүн шилжсэн тохиолдлуудад энэхүү гэрээний дэвтэр ашиглах нөхцөлд заасны дагуу хамтран хариуцагч төлбөр, тооцооны зөрчил гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан барагдуулна.
- 4.16. Хэрэглэгч нь энэхүү гэрээг зөрчиж, цахилгаан эрчим хүчийг зүй бусаар ашигласан нь тогтоогдсон, тоолуурын баталгаат хугацаа дууссан бол суурилагдсан хүчин



- чадал, ажиллавал зохих цагийг үндэслэн хангагчийн эрх бүхий ажилтан нөхөн тооцоог хийнэ.
- 4.17. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан төлбөр тооцооны зөрүүг талууд харилцан тохиролцож дараа сарын тооцоонд оруулан нөхөн тооцно.
- 4.18. Тооцооны хэмжих хэрэгслийг хангагч хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон явалтын) дахь алдагдлыг шугам сүлжээг хэрэглэгч хариуцна.
- 4.19. Хэрэглэгч нь худалдан авсан цахилгаан эрчим хүчний тооцоог хангагч байгуулагатай харилцан акт протокол үйлдэж баталгаажуулна.
- 4.20. Энэхүү гэрээнд заагдсан үйлчилгээ, төлбөр хураамжийн тухай мэдээллийг ХҮТ-д биеэр ирж, эсвэл утсаар болон "БЗӨБЦТ" ТӨХК-ийн цахим хуудаснаас авч болно.
- 4.21. Зөрчилтэй хэрэглэгчдэд нөхөн тооцоо хийх ба хангагчийн эрх бүхий ажилтан нөхөн тооцооны акт үйлдэж төлбөрийг хэрэглэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

#### **Тав. Тооцооны хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага**

- 5.1 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн цитэнд байрлуулсан тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангагч хариуцна.
- 5.2 Хэрэглэгчийн өмчлөлийн хашаа, байранд суурилуулсан хангагчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.
- 5.3 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг хангагч өөрийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслээр солих хүртэлх хугацаанд хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцох бөгөөд тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.
- 5.4 Хэрэглэгчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслийг баталгаажуулахтай холбогдон гарах зардлыг хэрэглэгч өөрөө хариуцна.
- 5.5 Баталгаажуулах хугацаанаас өмнө хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдаж баталгаажуулах шаардлагатай болсон эсвэл хэрэглэгчийн хүсэлтээр тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгаж баталгаажуулах тохиолдолд хэрэглэгч үйлчилгээний хураамжийг урьдчилан төлөх үүрэг хүлээнэ.
- 5.6 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах явцад тооцооны хэмжих хэрэгслийг оролдсон, гэмтээсэн шинж тэмдгүүдийг илрүүлсэн бөгөөд үүнд хэрэглэгчийн үйлдэл гарцаагүй нөлөөлсөн гэдгийг тогтоосон бол энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж хангагчийн эрх бүхий ажилтан акт үйлдэн, тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байсан хугацаанд ногдох дутуу тооцсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцож нэхэмжилнэ.
- 5.7 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн цитэнд байрласан тоолуур хэмжих хэрэгслийн битүүмжлэл алдагдсан, дутуу тоолсон, эвдэрсэн гацсан алдагдсан бол энэхүү гэрээний 4.6. заалтыг баримтлан дутуу тооцогдсон эрчим хүчийг нөхөж тооцно.
- 5.8 Тоолуур баталгаажуулах, солих үеийн тоолуургүй хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тооцоог хэрэглэгчийн сүүлийн 3 сарын дундаж хэрэглээг тоолуургүй байсан өдрийн тоогоор үржүүлэн тооцож авна.
- 5.9 Хэрэглэгчийн баталгаажуулахаар авчирсан тоолуур нь компанийн эзэмшлийн бөгөөд, хулгайд алдагдсан тоолуур байвал шалгаж тогтоон тоолуурыг хураан авч алдагдсан нэгжид буцаана. Энэ тохиолдолд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй.
- 5.10 Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг санаатайгаар удаа дараа алдагдуулж хангагчийн шаардлагыг биелүүлээгүй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах ба шүүхийн байгууллагад шилжүүлнэ.

5.11 Өөрийн эзэмшлийн тоолуурт хэрэглэгч нь 2 сар дараалан хангагчийн эрх бүхий ажилтныг нэвтрүүлээгүй бол хангагч хэрэглээг түдгэлзүүлж хэрэглээг сүүлийн 3 сарын дунджаар тооцно. Нэвтрүүлээгүй тохиолдолд тэмдэглэл хөтөлж хөндлөнгийн гэрчээр баталгаажуулна.

### **Зургаа. Талуудын харилцан хүлээх хариуцлага**

- 6.1. Тооцооны хэмжих хэрэгсэл алдагдсан, гэмтсэн тохиолдолд тооцооны хэмжих хэрэгсэл суурилуулах, гэмтэл устгахтай холбогдон гарах зардлыг тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг энэхүү гэрээний 5.1, 5.2-д заасан хариуцагч гаргана.
- 6.2. Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол гэрээнд заасан алдангийг төлөх бөгөөд хуулийн дагуу хангагч нь хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 6.3. Хангагч нь цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болж хэрэглэгчид хохирол учруулсан бол хангагчид мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор хохирлыг шалгаж, актыг талууд 5 хоногийн дотор хамтран тогтооно. Гарсан хохирлыг нэг сарын дотор буруутай тал хариуцан төлнө. Аль нэг талын гарын үсэг зураагүй акт нь нөхөн төлөх үндэслэл болохгүй.
- 6.4. Хэрэглэгчийн буруутай үйлдэл мөн өөрийн өмчлөлийн буюу эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчийн ажилтнуудад хохирол учруулсан бол холбогдох хууль, дүрмийн дагуу хохирлыг бүрэн төлнө.
- 6.5. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн мөн өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ тоног төхөөрөмж эвдэрсний улмаас хангагч болон бусад хэрэглэгчдэд хохирол учруулсан бол хохирлыг акт үйлдэн баталгаажуулан төлнө.
- 6.6. Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа тоног төхөөрөмждөө засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад байгууллагад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг нөхөн төлнө.
- 6.7. Зар мэдээлэл, сануулгыг хэрэглэгчийн гэрээнд заасан нэр, хаяг, утасны дугаараар хүргүүлэх бөгөөд холбоо барих нэр, хаяг, утасны дугаар өөрчлөгдсөнийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй.
- 6.8. Хангагчийн эрх бүхий ажилтан хуулийн дагуу хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түтгэлзүүлж, тоног төхөөрөмжийг битүүмжилсэн байхад дур мэдэн зөвшөөрөлгүй залгаж цахилгаан эрчим хүчийг зүй бусаар ашигласан бол гэм буруутай этгээдэд эрчим хүчний хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.9. Хэрэглэгчид гэрээний хугацаа дууссан болон гэрээнд өөрчлөлт оруулахаар мэдэгдэл өгөөд ирэхгүй байгаа нь хэрэглэгч үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.10. Цахилгаан эрчим хүчний тасалдлаас учирсан хохирлыг дор дурьдсан тохиолдолд хангагч хариуцахгүй.
- 6.6.1 Байгалийн гэнэтийн аюул /аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт/ тохиолдсон
- 6.6.2 Хангагчийн тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан
- 6.6.3 Хэрэглэгчийн цахилгаан дамжуулагч шугамыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан
- 6.6.4 7-оос дээш хоногоор эзгүй байх тохиолдолд хангагчид мэдэгдээгүй бол
- 6.6.5 Хэрэглэгчийн холбоо барих нэр хаяг, утасны дугаар өөрчлөгдснийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд гарах хохирлыг
- 6.6.6 Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт саатал, гэмтэл гарснаас цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Гэрээнд үл ойлголцол гарч талуудын хооронд гарсан маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.2. Хэрэв маргааныг 2 тал харилцан тохиролцон шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3. Хангагч болон хэрэглэгчийн хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбогдон гарсан маргааныг стандартчилал хэмжил зүйн эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлж болно.

### Долоо. Гэрээ дүгнэх, сунгах, өөрчлөх, цуцлах

- 7.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулж болно.
- 7.2 Хангагч, хэрэглэгч талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийг бичгээр үйлдэж гэрээнд тусган баталгаажуулна.
- 7.3 Хангагч, хэрэглэгчийн хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон хавсралтыг техникийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд талууд заавал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 7.4 Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон НЭГДҮГЭЭР хавсралт, хэрэглэгчийн төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн хугацааг тодорхойлсон ХОЁРДУГААР хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 7.5 Гэрээний хавсралтуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хангагч утсаар болон бичгээр хэрэглэгчид мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд хэрэглэгч гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.
- 7.6 Хэрэглэгч гэрээ дуусахаас нэг сарын өмнө хангагчтай тооцоо нийлж, гэрээг дүгнэсэн протокол үйлдэнэ.
- 7.7 Гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Талуудын хадгалсан хувь тус бүр нь нэгэн адил хүчин төгөлдөр байна.
- 7.8 Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хуульд зааснаас гадна дараах нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцална.
  - Аль нэг талын санаачилгаар
  - Хэрэглэгч гэрээний үүргээ зөрчсөн, хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол
- 7.9 Гэрээ цуцлагдсан хэрэглэгч хангагчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгсэлтэй бол хангагч тооцооны хэмжих хэрэгслийг гурааж авах бөгөөд хэрэглэгчийг дахин шугам сүлжээнд холбогдох боломжийг хязгаарласан техникийн арга хэмжээг авна.
- 7.10 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй болон хэрэглэгч төлбөрийн зөрчилгүй байвал гэрээг анх заасан хугацаагаар гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн дахин нэг удаа сунгагдсанд тооцно.
- 7.11 Тоолуур хэмжих хэрэгслийг хангагч байгууллагад мэдэгдэлгүй дур мэдэн солих, холболтыг өөрчлөх, битүүмжлэлийн 3 дугаар лацыг оролдох, тасалсан үйлдлийг 3-аас дээш удаа үйлдсэн нь нотлогдвол нэг талын санаачилгаар гэрээг дуусгавар болгоно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### Хангагчийг төлөөлж:

"БЗӨБЦТС" ТӨХК-ийн .....

ЦТСС-ын дарга .....

Ерөнхий /ахлах/ ня-бо .....

Ерөнхий /ашиглалтын/ инженер .....

Борлуулалтын инженер .....

Харилцах утас .....

#### Хэрэглэгчийг төлөөлж:

Хэрэглэгчийн .....

Захирал /Дарга/ .....

Ерөнхий ня-бо .....

Ерөнхий инженер .....

Цахилгааны инженер .....

Харилцах утас .....

